

«ТӨРӨЛХТНИЙ ЭЗЭН» ХЭМЭЭХ ТӨМӨР ХОНИН ЖИЛ

Л. Тэрбиш

1. «Төрөлхтний эзэн» хэмээх төмөр хонин жилийн өнгө байдал

«Төрөлхтний эзэн» хэмээх төмөр хонин жилд хүн, малын өвчин арилж, Чинагш, инагш тэмцэлдээн үгүй, зохицолдон, үнээ мал тэргүүтний сүү арвижимуй. Жилийн эзэн од нь Чу хэмээх од бөгөөд үр нь хур, бороо орон, үр тариа дэлгэрэн, хамаг амьтан тэмцэл маргаангүй амраглан, жаргаж, баясан үйлдмүй. Жилийн эзэн гариг нь Сумъяа гариг бөгөөд үүний үр дүн: хур буун, эмийн ургамлын шим төгөлдөржинө. Ус мөрөн дээрээсээ арвижин, ой цэцэрлэгийн үр жимс дэлгэрнэ. Үхэр малын сүү арвижина. Залуус баясан наадан бүжимүй. Хаад ноёд энэрэхүй бээр улс орноо тэтгэнэ.

2. Ертөнцийн эцэг, эхийн золголт

Монгол зурхайд шинийн хоногийн гариг болон ордны хоногийн гаригуудын харилцан байршилаар тухайн саруудын төлөв байдлыг илэрхийлэх арга байдаг. Түүнийгээ (гаригуудын харилцан байршил) Ертөнцийн эцэг, эхийн золголт гэдэг. Дурдсан ёсоор бол хаврын дунд, зуны дунд, зуны адаг, намрын эхэн, өвлийн эхэн, өвлийн адаг саруудад цаг агаарын тавгүй байдлууд үе үе гарч болзошгүй ажээ. Харин хаврын адаг, зуны эхэн, намрын дунд, хаврын эхэн саруудад хур оромтгой, салхи шуурга багатай цаг агаар тогтуун, тариа төмс, эд хэрэглэл арвижихын нигууртай, өвлийн адаг сард салхи шуурга, цасан шамаргатай байж болзошгүй ажээ.

3. Төмөр хонин жилийн шороон үхрийн шинж

Шороон үхрийн шинж хэмээх жилийн төлөв байдлыг мэдэх аргын гол агуулга нь тухайн жилийн болон тухайн жилийн хаврын амьсгал орох өдрүүдийн махбодиудаар, хооронд нь хэрэлдүүлэн тоолж, үхэр хийгээд үхэр хариулаачийн зурагт бүдүүвчийг гарган түүгээрээ жилийн өнгө байдлыг тогтоох явдал юм. Миний бие өөрийн багш зурхайч агсан Б. Жинбаагийн хувийн номын санд хадгалагдаж байсан (хожим нь надад хайрласан) «Шороон үхрийн шинжийг гаргах ёс галбаран модны, мөчир оршивай» хэмээх бэсрэг төвт судрыг үндэслэн төмөр хонины жилтийн шороон үхрийг гаргахул: Цагаан толгойтой, шар биетэй, шар ходоодтой, эвэр, сүүл, чих нь ногоон, улаан омруутай, дөрвөн шийр нь улаан үхэр, сүүлээ баруун тийш шарваад үхэр хариулаачийн ард явж байх юм.

Үхэр хариулаач нь өвгөн хүн бөгөөд, олсон шилбүүртэй, хоёр гутлаа сугавчилсан, үхрийнхээ өмнө явж байна. Хүний нүүр нь улаан, хувцасны өнгө хар, шар бүстэй, үс нь баруун чихний ар, зүүн чихний урдуур унжсан байна.

Үхрийн шинжийг дурдахул: Биеийн өнгөнд шар голчлон буй тул үр тариа арвижин, ногоо ургамал сайн гараад, хурмал өвчин өчүүхэн төдий болох аж. Толгой цагаан болохоор жилийн эхэн болон хавар, дөрвөн улирлын эхэнд хуртай байх гэнэ. Эвэр, сүүл, чих нь ногоон болохоор үе үе салхилах юм байна. Омруу улаан болохоор зуны эхэнд ха-

луун гандуу болох ажээ. Дөрвөн шийр улаан болохоор жилийн эцсээр хургүй байх аж. Үхэр хариулаачин өвгөн хүн байгаа нь өвгөчүүл, настан буурлууд налгар байхын дохио гэнэ. Бүс болон хувцасны өнгийг төр, шашны явдлыг гаргасан байдаг хэмээн өтгөс хуучлах авч эл бяцхан сударт энэ талаар өгүүлсэн зүйлс байхгүй байна.

4. Цасан чихрийн амт мэт жилийн үр

Зурхайд улиран өнгөрч буй жилийн давталтыг ашиглан жилийн байгал, цаг уурын ерөнхий төлөвийг найман үзүүлэлтээр гаргадаг. Түүнд хамгийн их нь 17, хамгийн бага нь 5 бөгөөд 12 бол дунд зэрэг байх жишээтэйг өөрийн оюунаар мэдэх аж. Чингэвэл төмөр хонин жилд хур 17, үр 5, өвс 11, Сэрүүн 9, чийг 11, салхи 13, арвидал 11, хомсдол 1:5 байх ажээ.

Төмөр хонин жилийн улирлууд

Хур усан хаврын тэргүүн сарын шинийн тавны 12 ц. 4 м. 42 с-д эхэлнэ. Энэ улиралд өчүүхэн хурд цасан буцаж эхэлнэ, өөрөөр хэлбэл цасан шамрага орж эхэлнэ.

Ичигсэд хөдлөх —хаврын тэргүүн сарын 21-ний 10 ц. 10 м. 33 с-д эхэлнэ. Хаврын их салхи босно.

Хаврын хугас дунд —хаврын дунд сарын 5-ны 11 д. 4 м. 47 с-д эхлэнэ. Улаан салхи босно. Хурыг хүсэгч бялзуухай шувууд ирнэ.

Ханш нээх хаврын дунд сарын 21-ний 15 ц. 8 м-д эхлэнэ. Огторгуйн тоос арилж цэлмэнэ. Таримал мод тарих цаг, харз ус дэлбэрнэ, морин хараацай ирнэ.

Тариалангийн хур— хаврын адаг сарын 6-ны 22 ц. 18 м. 47 С-д эхлэнэ. Оныхоо үр тариа тарихад хамгийн тохиромжтой үе. Бух цахлай, тогоруу тэргүүтэн шувууд ирнэ.

Зуны уур орох-хаврын адаг сарын 22-ны 8 ц. 38 м. 12 с-д болно. Дулаарч эхлэнэ. Хөхөө шувууд донгодож эхлэнэ. Гүн худгийн ус л хүйтэн байна. Их шар цэцэг амаа нээнэ.

Өчүүхэн дүүрэн — зуны тэргүүн сарын 8-ны 21 ц. 44 м. 32 с-л эхлэнэ. Энэ улирлыг малын бага надлага ч гэж нэрлэх ёсон буй. Сөл хөөж малаа таргалуулах үе. Нохойн хошууны цэцэг ургаж эхлэнэ.

Буудай боловсрох — зуны тэргүүн сарын 24-ний 13 ц. 14 м. 21 с-д эхлэнэ. Буудайн ур хүндэрч хөхрөнө.

Зуны туйл — зуны дунд сарын 11-ний 5. 51 м. 26 с-д эхлэнэ. Модны жимс толгойлж буурцаглана.

Өчүүхэн халуун-зуны дунд сарын 28-ны 23 ц. 31 м. 44 С-д эхлэнэ. Модны жимс боловсрох явцад үндэс нь хорхойтож болзошгүй. Мал сүрэг гүйцэд цална. Ус хортой болох үе энэ улирал эхэлснээс хойш долоо хоног үргэлжилнэ. Энэ үед эмийн ургамал түүх болон усан эмчилгээг аль болохоор тэвчивээс сайн болой.

Их Халуун—зуны адаг сарын 12-ны 17 ц. 1 м. 4 с-д эхлэнэ. Мал ундаасах нь ихдэнэ. Хөхөөн дуу тасрана.

Намрын уур орох — зуны адаг сарын 28-ны 9 р. 34 м. 50 с-д эхлэнэ. Мөндөр орж эхлэнэ. Салхи хөдлөнө.

Халуун эргэх намрын тэргүүн сарын 14-ний О цаг 19 м. 46 с-д эхлэнэ. Энэ улирлыг мөн сэрүүн цаг гэж нэрлэх ч ёсон буй. Халуун хомсдож сэрүүн болно. Хур татарч мөрөн голын ус хомсдоно.

Цагаан шүүдэр -Намрын тэргүүн сарын 30-ны 12 д. 48 м. 20 с-д эхлэнэ. Усны чанар сайжирна. Огторгуй цэлмэг тунгалаг сайхан байсан ч мод өвс тэргүүтний өнгө хувирна. Энэ улирлаас хойш усны засал, усан эмчилгээнд шамдваас нэн тохиромжтой.

Намрын хугас дунд — намрын дунд сарын 15-ны 22 ц. 14 м. 46 с-д эхлэнэ. Усны шувууд буцна. Ургамал бүхний өнгө хувирна. Мөнх ногоон ургамал л гойд сайн болно.

Хүйтэн шүүдэр — Намрын адаг сарын 2-ны 4 ц. 38 м. 36 с-д эхлэнэ. Нүхэнд амьдрагч амьтад ичиж эхлэнэ. Тэнгэрийн дуу тасрана.

Хяруу унах намрын адаг сарын 16-ны 7 цаг 40 м. 54 с-д эхлэнэ. Газрын хөрс хөлдөнө. Хяруу унаж, хур цасан болон хувирна.

Өвлийн уур орох -Өвлийн тэргүүн сарын 2-ны 7 ц. 41 м. 32 с-д эхлэнэ. Ус зайрмагтаж, хүйтний эрч ирнэ.

Өчүүхэн цасан — Өвлийн тэргүүн сарын 17-ны 5ц. 42 с-д эхлэнэ. Хүйтний эрч чангарч, мал хийгээд араатан амьтны үс гүйцнэ.

Их цасан -Өвлийн дунд сарын 2-ны 10 м. 30 с-д эхлэнэ. Хүйтний эрч улам нэмэгдэж, ус хөлдөнө.

Өвлийн туйл — өвлийн дунд сарын 16-ны 17 ц. 50 м. 17 С-д эхлэнэ. Ес эхлэнэ.

Өчүүхэн хүйтэн -Өвлийн адаг сарын 2-ны 10 ц. 48 м. 29 с-д эхлэнэ. Хүйтний эрч ихэд чангарна. Араатан амьтан даарч, ийш тийш гүйдэнэ.

Их хүйтэн — өвлийн адаг сарын 17-ны 4 ц. 1 с-д эхлэнэ. Хүйтэн туйлдаа хүрнэ. Энэ улирлын дунд үеэс эхлэн хүйтний эрч үе үе чангарч үе үе сулрана.